

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Элчин сайдын
яам нээн ажиллуулах тухай

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.5.5.-т “гуравдагч хөрш”-ийн бодлогын хүрээнд түншлэлийн харилцааг өргөжүүлэн, эдийн засгийн хамтын ажиллагааг бэхжүүлж, бусад улстай харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэх чиглэлээр идэвхтэй ажиллана”, 4.5.8.-т “Улс төр, эдийн засгийн харилцааны түвшин, ач холбогдол, тухайн улсад оршин суугаа монгол иргэд болон харилцан зорчиж байгаа иргэдийн тоо зэргийг харгалзан Дипломат төлөөлөгчийн газруудын байршил, бүтэц, орон тоог оновчтой болгоно” гэж тус тус заасан.

Төв Азийн бүс нутгийн зах зээлд томоохонд тооцогдох 35 сая гаруй хүн амтай Узбекистан нь хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн хөгжлөөр тэргүүлдэг тул Монгол Улсын хүнсний аюулгүй байдлыг хангах зорилтод нийцсэн эрүүл хүнсний бүтээгдэхүүний хангамжийг нэмэгдүүлэх, төрөлжүүлэх чиглэлээр хамтран ажиллах, манай үндэсний үйлдвэрлэгчдийн бүтээгдэхүүнийг тухайн бүс нутагт таниулах, эдийн засгийн харилцааг өргөжүүлж худалдааны эргэлтийг нэмэгдүүлэх, мах, махан бүтээгдэхүүний экспортын чиглэлээр хамтран ажиллах өргөн боломжтой улс юм.

Узбекистан нь хуучин Зөвлөлт Холбоот Улсын бүрэлдэхүүнд байсан Төв Азийн орнуудтай харьцуулахад манай хоёр хөрштэй хил залгадаггүй, Хамтын аюулгүй байдлын гэрээний байгууллага, Евразийн эдийн засгийн холбооны гишүүн бус, бие даасан гадаад бодлого явуулахыг эрхэмлэдэг, тухайн бүс нутагтаа улс төрийн нэр хүндтэй улс. Өнөөдрийн байдлаар тус улсад гадаадын 44 улсын Элчин сайдын яам, 2 Ерөнхий консулын газар, Олон улсын 18 байгууллагын төлөөлөгчийн газар ажиллаж байна. Тус улс нь гадаад бодлогын хүрээнд сүүлийн жилүүдэд бүхий л салбарыг хамарсан өргөн хүрээнд шинэчлэлийг өрнүүлж байна. Тухайлбал, Узбекистан нь 2020 онд Евразийн эдийн засгийн холбоонд ажиглагч статустай болсон, саяхан Дэлхийн худалдааны байгууллагад элсэх хүсэлтээ илэрхийлээд байгаа болно.

Хоёр талын худалдааны эргэлт сүүлийн жилүүдэд аажмаар өсөн 2022 онд 10,4 сая ам.долларт хүрсэн бөгөөд хоёр улсын Худалдаа, аж үйлдвэрийн танхимууд 2022 онд Ташкент хотод Монгол, Узбекистаны бизнес уулзалтыг хамтран зохион байгуулсан. Монгол Улсын хүнсний аюулгүй байдлыг хангах, нийлүүлэгч улсын тоог нэмэгдүүлэх үүднээс улс төрийн хувьд төвийг сахисан, бүс нутагтаа нөлөө бүхий улстай илүү түлхүү ойр ажиллах нь зүйтэй хэмээн үзэж хоёр талын харилцааг өргөжүүлэх, хамтын ажиллагааны эрх зүйн үндсийг тогтооход чиглэсэн Засгийн газар хоорондын хэлэлцээр, санамж бичгүүдийг байгуулахаар ажиллах төлөвлөгөөтэй байна.

Иймд бүс нутагтаа улс төр болон эдийн засгийн хувьд ач холбогдол бүхий улсад Монгол Улсын Элчин сайдын яамыг нээн ажиллуулах бодитой хэрэгцээ, шаардлага байгааг харгалзан Бүгд Найрамдах Узбекистан Улсын нийслэл Ташкент хотод Монгол Улсын Элчин сайдын яам нээн ажиллуулах саналыг 2023 оны 9 дүгээр сарын 06-ны өдөр Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 2023 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн хуралдаанаар уг саналыг зөвшилцөн дэмжсэн шийдвэр гаргасан тул асуудлыг айлын талд дипломат шугамаар тавьж, зөвшөөрсөн хариуг авсан.

Улмаар Гадаад харилцааны сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Сангийн сайд нар хамтран "Бүгд Найрамдах Узбекистан Улсын нийслэл Ташкент хотод Монгол Улсын Элчин сайдын яам нээн ажиллуулах тухай" Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн үзэл баримтлалыг баталсны үндсэн дээр Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулав.

Элчин сайдын яамыг 3 орон тоотой ажиллуулахаар төлөвлөсөн бөгөөд холбогдох зардлыг 2024 оны төсөвт тусгасан болно.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Элчин сайдын
яам нээн ажиллуулах тухай

Монгол Улсын гадаад харилцаа улам өргөжин хөгжихийн хэрээр гуравдагч хөрш болон бусад улстай хамтын ажиллагааг гүнзгийрүүлэн өргөжүүлэх, ялангуяа худалдаа, эдийн засгийн чиглэлийн харилцан ашигтай хамтын ажиллагааг тэлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.5.5.-т “гуравдагч хөрш”-ийн бодлогын хүрээнд түншлэлийн харилцааг өргөжүүлэн, эдийн засгийн хамтын ажиллагааг бэхжүүлж, бусад улстай харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэх чиглэлээр идэвхтэй ажиллана”, 4.5.8.-т “Улс төр, эдийн засгийн харилцааны түвшин, ач холбогдол, тухайн улсад оршин суугаа монгол иргэд болон харилцан зорчиж байгаа иргэдийн тоо зэргийг харгалзан Дипломат төлөөлөгчийн газруудын байршил, бүтэц, орон тоог оновчтой болгоно” гэж тус тус заасан.

Төв Азийн бүс нутгийн зах зээлд томоохонд тооцогдох 35 сая гаруй хүн амтай Узбекистан Улс нь хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн хөгжлөөр бүс нутагтаа тэргүүлдэг тул Монгол Улсын хүнсний аюулгүй байдлыг хангах зорилгод нийцсэн эрүүл хүнсний бүтээгдэхүүний хангамжийг нэмэгдүүлэх, төрөлжүүлэх чиглэлээр хамтран ажиллах, манай үндэсний үйлдвэрлэгчдийн бүтээгдэхүүнийг тухайн бүс нутагт таниулах, эдийн засгийн харилцааг өргөжүүлж худалдааны эргэлтийг нэмэгдүүлж, Монгол Улсаас мах, махан бүтээгдэхүүн, арьс, шир, ноос ноолуур нийлүүлэх, Узбекистан Улсаас жимс жимсгэнэ, нарийн ногоо зэрэг бараа бүтээгдэхүүн импортлох, харилцан ашигтай худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх өргөн боломжтой улс юм.

Узбекистан нь хуучин Зөвлөлт Холбоот Улсын бүрэлдэхүүнд байсан Төв Азийн зарим орнуудтай харьцуулахад манай хоёр хөрштэй хил залгадаггүй, Хамтын аюулгүй байдлын гэрээний байгууллага болон Евразийн эдийн засгийн холбооны гишүүн бус, бие даасан гадаад бодлого явуулахыг эрхэмлэдэг, тухайн бүс нутагтаа улс төрийн нэр хүндтэй улс юм. Өнөөдрийн байдлаар Бүгд Найрамдах Узбекистан Улс дэлхийн 130 гаруй улстай дипломат харилцаа тогтоогоод байна. Тус улсад гадаадын 44 улсын Элчин сайдын яам, 2 Ерөнхий консулын газар, 18 Олон улсын байгууллагын төлөөлөгчийн газар ажиллаж байна. Тус улс нь гадаад бодлогын хүрээнд сүүлийн жилүүдэд бүхий л салбарыг хамарсан өргөн бүхий шинэчлэлийг өрнүүлж байна. Тухайлбал, Узбекистан нь 2020 онд Евразийн эдийн засгийн холбоонд ажиглагч статустай болсон, саяхан Дэлхийн худалдааны байгууллагад элсэх хүсэлтээ илэрхийлээд байгаа болно.

Монгол Улсаас ЗХУ-ын Ташкент хотноо 1970-1994 онд Консулын газар үйл ажиллагаа явуулж байсан бөгөөд өнөөгийн байдлаар монголын тал Астана дахь ЭСЯ, узбекистаны тал Бээжин дэх ЭСЯ-аар тус тус хавсран сууж байна.

Хоёр талын худалдааны эргэлт сүүлийн жилүүдэд аажмаар өсөн 2022 онд 10,4 сая ам.долларт хүрсэн бөгөөд хоёр улсын Худалдаа, аж үйлдвэрийн танхимууд 2022 онд Ташкент хотод Монгол, Узбекистаны бизнес уулзалтыг хамтран зохион байгуулсан.

Монгол, Узбекистаны худалдааны статистик мэдээлэл								
Нэр	2019 он		2020 он		2021		2022 он	
	Экспорт мян.\$	Импорт мян.\$	Экспорт мян.\$	Импорт мян.\$	Экспорт мян.\$	Импорт мян.\$	Экспорт мян.\$	Импорт мян.\$
Үнэ	58.6	2 025.3	98.4	2 506.7	376.5	3 453.0	4 193.8	6 225.7
Нийт	2,0 сая ам.доллар		2,6 сая ам.доллар		3,8 сая ам.доллар		10,4 сая ам.доллар	

Украинд өрнөж буй үйл явдалтай холбогдуулан Монгол Улс Узбекистан болон тус бүс нутгийн бусад улсаас хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэх чиглэлээр хамтран ажиллаж байна.

Узбекистан Улстай Засгийн газар хоорондын хэлэлцээр, санамж бичгүүдийг байгуулах, тухайлбал, иргэдийн солилцоо, аялал жуулчлалыг дэмжих хүрээнд хоёр улсын хооронд шууд нислэг үйлдэх, агаарын замыг нээх зорилгоор Агаарын харилцааны тухай, тээвэр, логистикийн салбарын хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх чиглэлд Олон улсын авто тээврийн тухай Засгийн газар хоорондын хэлэлцээрийг байгуулах зэргээр ажиллаж байна.

Түүнчлэн Дубай хотноо болсон Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаарх дэлхийн удирдагчдын дээд түвшний уулзалтын үеэр буюу 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдөр Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх Бүгд Найрамдах Узбекистан Улсын Ерөнхийлөгч Ш.Мирзиёев нар, Бишкек хотноо болсон ШХАБ-ын гишүүн орнуудын Засгийн газрын тэргүүн нарын өргөтгөсөн хуралдааны үеэр буюу 2023 оны 10 дугаар сарын 25-нд Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ Узбекистан Улсын Ерөнхий сайд А.Арипов нар тус тус албан уулзалт хийсэн. Мөн Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг 2023 оны 03 дугаар сарын 08-09-ний өдрүүдэд Бүгд Найрамдах Узбекистан Улсад албан ёсны айлчлал хийж, Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Узбекистан Улсын Засгийн газрын хооронд хоёр талт хамтын ажиллагааны хамтарсан комисс байгуулах тухай хэлэлцээрийг байгуулав.

Улс төрийн хувьд төвийг сахисан, бүс нутагтаа улс төр болон эдийн засгийн хувьд нөлөө бүхий улсад Монгол Улсын Элчин сайдын яамыг нээн ажиллуулах бодитой хэрэгцээ, шаардлага байгааг харгалзан Бүгд Найрамдах Узбекистан Улсын нийслэл Ташкент хотод Монгол Улсын Элчин сайдын яам нээн ажиллуулах саналыг 2023 оны 09 дүгээр сарын 06-ны өдөр Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 2023 оны 10

дугаар сарын 10-ны өдрийн хуралдаанаар уг саналыг зөвшилцөн дэмжсэн шийдвэр гаргасан тул асуудлыг айлын талд дипломат шугамаар тавьж, зөвшөөрсөн хариуг авсан.

Улмаар Гадаад харилцааны сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Сангийн сайд нар хамтран “Бүгд Найрамдах Узбекистан Улсын нийслэл Ташкент хотод Монгол Улсын Элчин сайдын яам нээн ажиллуулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн үзэл баримтлалыг баталсны үндсэн дээр Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулав.

Элчин сайдын яамыг 3 орон тоотой ажиллуулахаар төлөвлөсөн бөгөөд холбогдох зардлыг 2024 оны төсөвт тусгасан болно.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР